

ХҮНИЙ НӨӨЦИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

Хүний нөөцийн нийлүүлэлтийн талаар авч хэрэгжүүлэх бодлого

“МИАТ” ТӨХК нь Монгол Улсын хуулиуд, Иргэний нисэхийн хууль, дүрэм, Компанийн дүрэм, журмууд, зааврууд, нислэгийн аюулгүй байдал, чанарын бодлогын хүрээнд хүний нөөцийн нийлүүлэлтийн талаар дараах зарчмыг мөрдөн ажиллаж байна. **Үүнд:**

Иргэний нисэхийн мэргэжлээр гадаад улс орнуудад мэргэжил эзэмшсэн, их дээд сургууль төгссөн буюу мэргэжил дээшлүүлсэн, магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цол хамгаалсан хүнийг тэргүүн ээлжинд ажилд авч ажиллуулах.

Эзэмшсэн мэргэжлээр тогтвор суурьшилтай ажиллаж байсан мэргэшсэн, гадаад хэлний ярианы болон бичгийн өндөр чадвартай хүнийг тэргүүн ээлжинд ажилд авч ажиллуулах.

Боломжтой бол сул орон тоонд заавал ажилтан томилохгүйгээр цалингийн зардлыг хэмнэх.

Хүний нөөцийн бүртгэлийн сан бүрдүүлж ажилд орох хүсэлт гаргасан хүний материалыг хүлээн авч компанид мөрдөгдөж байгаа албан тушаалын ажлын байрны тавигдах шаардлагыг бүрэн хангасан хүнийг хүний нөөцөд бүртгэн авч тухайн орон тоо сул гарсан тохиолдолд дуудан нээлттэй сонгон шалгаруулж ажилд авна.

Жил бүрийн 1 дүгээр сард багтаан тэтгэвэрт гарах ажилтнуудын судалгааг гаргана. Тэтгэвэрт гарах ажилтны орон тоон дээр хүний нөөц бүрдүүлэн төлөвлөгөө гарган ажиллана.

Албан тушаалд ажилтныг дэвшүүлэн ажиллуулахтай холбогдсон харилцааг Иргэний нисэхийн хууль, Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль, Компанийн дүрэм, Үйл ажиллагааны зааврууд, холбогдох дүрэм, журмууд, ажлын байрны тавигдах шаардлагыг үндэс болгон ажиллана.

Түүнчлэн компанийн зүгээс аль болох ажилчдад хөгжиж дэвших, дотроо албан тушаал ахих боломж олгохын тулд бүх сул орон тооны талаар дотоод сүлжээний цахим шуудан, мэдээллийн самбаруудад зарлан хэрэгжүүлж байна.

2025 онд хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгааг сар болгон тогтмол хийж ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй олон нийтийн дунд зарлан зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд нийт 13 төрлийн албан тушаалын ажлын байранд 125 хүнийг нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, шалгаруулж ажилд авсан.

ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХЭРХЭН САЙЖРУУЛЖ БАЙГАА ТАЛААР

Ажилтнуудыг тасралтгүй суралцах, өсөж хөгжих эрмэлзлийг идэвхитэй дэмжин, мэдлэг боловсролтой, ур чадвартай хүний нөөц бий болгох зорилгоор жил бүр Гадаад, Дотоод сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

2025 онд Гадаад улсад 20 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 116 ажилтныг (Б737, Б767, Б787, CRJ700 агаарын хөлгийн нисгэгчийн шилжих болон давтан, Агаарын хөлгийн засвар үйлчилгээ, Маркетинг борлуулалт, Бүхээгийн үйл ажиллагаа, Карго тээвэр, Газрын үйлчилгээ, нислэг зохицуулалт) г.м хамруулан мэргэшүүлсэн. (2,1 тэрбум төгрөг зарцуулсан).

2025 онд дотоодод өөрийн МИАТ Сургалтын төвд давхардсан тоогоор 81 төрлийн сургалтад 5482 ажилтныг (Газрын үйлчилгээ, Зорчигч бүртгэл, ХАБ, Нислэгийн аюулгүй байдал, Карго үйлчилгээ, Агаарын хөлгийн засвар үйлчилгээ, Суудал захиалга, Бүхээгийн үйл ажиллагаа, Аюулгүй ачаа, Нисэх баг, Нислэг зохицуулалт, Үйлчилгээний чанар, харилцаа хандлага) г.м бусад чиглэлийн сургалтад хамруулан мэргэшүүлсэн. (650 сая төгрөг зарцуулсан).

АЛБАН ХААГЧДЫГ ДЭМЖИХ, УРАМШУУЛАХ ТАЛААР

Зах зээлд өрсөлдөхүйц цалин хөлсний бодлого хэрэгжүүлэх, ажилтнуудыг идэвхижүүлэх, ажлын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, бүтээмж, ажлын гүйцэтгэл, ур чадварт тулгуурлан үндсэн цалинг 2022 онд 5-20 хүртэл хувь, 2023 онд 20 хувь, 2025 онд 10-20 хувиар тус тус нэмэгдүүлсэн.

Цаашид хэрэглээний үнийн өсөлт болон компанийн санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна.

“МИАТ” ТӨХК